ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ӨМА-2026/017/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өмнөговь аймаг<br>2026 он | Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр<br>Утас:70533539    Цахим хаяг:usukhbayarts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Т.Хонгорзул<br>Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Г.Шижирболд<br>Утас: 70533552 Цахим хаяг: umnugovi@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн : Ай Жэй Эй Эйч аудит ХХК<br>Аудитор: С.Сүрэнчимэг Утас: 77450279 99067036 Цахим хаяг:ijahaudit2020@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 2

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 4

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 10

**3.1 Төлбөрийн акт** ........ 10

**3.2 Албан шаардлага** ........ 10

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 11

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.25 № 120

танай ______________-ны №______________ -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.НЯМСАМБУУ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 134,035.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бэлтгэсэн байна.

4626050183

F:\2.Бичиг хэрэг\2026он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

**Бусад асуудал хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 9 зорилтын хүрээнд 33 арга хэмжээг хэрэгжүүлэн 100.0 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

F:\2.Бичиг хэрэг\2026он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*/төгрөгөөр/*

| БАЛАНСЫН ЗҮЙЛ | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ** | 4 | **14,295,698.27** | **-** |
| Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/ | | 14,295,698.27 | |
| **АВЛАГА** | 5 | **-** | **12,745,698.27** |
| Татаас, санхүүжилтийн авлага | | | 12,745,698.27 |
| **УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР** | | | |
| **БАРАА МАТЕРИАЛ** | 6 | **35,779,075.40** | **11,004,119.00** |
| **Түүхий эд материал** | | **17,582,149.00** | **7,020,219.00** |
| Тусгай зориулалттай материал | | 17,582,149.00 | 7,020,219.00 |
| **Хангамжийн материал** | | **18,196,926.40** | **3,983,900.00** |
| Бичиг хэргийн материал | | 235,000.00 | 45,000.00 |
| Аж ахуйн материал | | 3,272,850.00 | |
| Бусад хангамжийн материал | | 14,689,076.40 | 3,938,900.00 |
| **НӨӨЦИЙН БАРАА** | | | |
| **БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | | | |
| **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **50,074,773.67** | **23,749,817.27** |
| **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ** | | | |
| **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 7 | **233,053,987.49** | **280,786,451.87** |
| **Биет хөрөнгө** | | **192,821,512.63** | **241,475,627.05** |
| Барилга, байгууламж | | 14,183,128.00 | 14,183,128.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (2,127,468.96) | (2,482,047.12) |
| Авто- тээврийн хэрэгсэл | | 80,000,000.00 | 80,000,000.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (56,666,666.61) | (69,999,999.93) |
| Машин, тоног төхөөрөмж | | 268,920,935.00 | 322,978,255.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (115,946,414.80) | (182,237,208.82) |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | | 7,640,000.00 | 86,150,000.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (3,182,000.00) | (7,116,500.08) |
| **БИЕТ БУС ХӨРӨНГӨ** | | **1,382,474.86** | **460,824.82** |
| Программ хангамж | | 4,608,250.00 | 4,608,250.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (3,225,775.14) | (4,147,425.18) |
| Бусад биет бус хөрөнгө | | 38,850,000.00 | 38,850,000.00 |
| **БУСАД ХӨРӨНГӨ** | 8 | **38,850,000.00** | **38,850,000.00** |
| **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | **233,053,987.49** | **280,786,451.87** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | | **283,128,761.16** | **304,536,269.14** |
| **Богино хугацаат өр төлбөр** | | | |
| **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | | **-** | **-** |
| Урт хугацаат зээл | 10 | | |
| **УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН** | | | |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | | **-** | **-** |
| **Засгийн газрын хувь оролцоо** | | **283,128,761.16** | **304,536,269.14** |
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | 38,850,000.00 | 38,850,000.00 |
| Хуримтлагдсан үр дүн | | 235,813,841.49 | 257,221,349.47 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 8,464,919.67 | 8,464,919.67 |
| **ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН** | | **283,128,761.16** | **304,536,269.14** |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | | 283,128,761.16 | 304,536,269.14 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*/төгрөгөөр/*

| ҮЗҮҮЛЭЛТ | Тодруулга | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО** | | | |
| **ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **1,656,293,631.88** | **1,649,187,675.00** |
| Улсын төсвөөс | | 1,282,773,000.00 | 1,357,533,300.00 |
| ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | | 251,903,831.88 | 287,826,875.00 |
| Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | | 121,616,800.00 | 3,827,500.00 |
| **Бараа, үйлчилгээний орлого** | | **133,649,122.50** | **168,972,484.43** |
| Өмчийн орлого | | | |
| Туслах үйл ажиллаганы орлогоос санхүүжих | | 2,880,000.00 | 1,440,000.00 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | | 103,735,152.50 | 144,453,469.43 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | | 27,033,970.00 | 23,079,015.00 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | 2 | **1,789,942,754.38** | **1,818,160,159.43** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ** | | | |
| **АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ** | | **1,259,684,468.74** | **1,473,809,189.25** |
| **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | | **1,123,704,226.15** | **1,308,178,998.23** |
| Цалин | | 522,217,008.62 | 603,991,977.27 |
| Нэмэгдэл зардал | | 307,459,572.77 | 341,771,926.01 |
| Унаа хоолны хөнгөлөлт | | 110,421,817.77 | 177,052,015.16 |
| Урамшуулал | | 183,605,826.99 | 185,363,079.79 |
| **Нийгмийн хамгааллын шимтгэл** | | **135,980,242.59** | **165,630,191.02** |
| Тэтгэврийн даатгалын шимтгэл | | 94,490,109.55 | 112,124,462.81 |
| Тэтгэмжийн даатгалын шимтгэл | | 10,368,972.04 | 13,097,357.49 |
| ҮОМШ өвчний даатгалын шмитгэл | | 5,198,788.43 | 7,664,976.93 |
| Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | | 5,184,433.43 | 6,548,678.76 |
| Эрүүл мэндийн даатгалын хураамж | | 20,737,939.14 | 26,194,715.03 |
| **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ** | | **480,536,858.95** | **307,453,774.80** |
| **Тогтмол зардал** | | **41,035,047.87** | **80,113,046.12** |
| Гэрэл цахилгааны зардал | | 7,091,605.07 | 7,998,772.65 |
| Түлш, халаалтын зардал | | 30,876,062.80 | 68,859,703.47 |
| Цэвэр, бохир усны зардал | | 3,067,380.00 | 3,254,570.00 |
| **Үйл ажиллагааны зардал** | | **260,030,433.08** | **188,902,849.05** |
| Хоол | | 1,500,000.00 | |
| Бусад бараа үйлчилгээний зардал | | 121,616,800.00 | 3,877,500.00 |
| Бичиг хэргийн материал | | 14,682,000.00 | 15,946,700.00 |
| Тээвэр, шатахууны зардал | | 1,700,000.00 | 4,381,000.00 |
| Шуудан холбооны зардал | | 3,629,594.00 | 3,765,200.00 |
| Дотоод томилолтын зардал | | 4,014,000.00 | 10,500,000.00 |
| Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | | 1,006,600.00 | 10,407,000.00 |
| Жижиг эд хогшил худалдан авах зардал | | 2,523,480.00 | 2,257,280.00 |
| Төлбөр, хураамж, жижиг татварууд | | 19,694,541.00 | 35,371,564.00 |
| Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | | 11,669,255.00 | 5,573,600.00 |
| Урсгал засварын зардал | | 2,798,390.00 | 102,000.00 |
| Элэгдлийн зардал | | 75,195,773.08 | 96,721,005.05 |

| | | | |
|---|---|---|---|
| **Хөтөлбөр арга хэмжээний зардал** | | **179,471,378.00** | **38,437,879.63** |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 113,417,792.00 | |
| Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал | | 34,563,091.00 | 250,000.00 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 28,610,495.00 | |
| Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн | | 1,152,000.00 | 576,000.00 |
| Хөрөнгийн | | 1,728,000.00 | 864,000.00 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | | | 36,747,879.63 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **3** | **1,740,221,327.69** | **1,781,262,964.05** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | | **49,721,426.69** | **36,897,195.38** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО** | | **-** | **-** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)** | | **-** | **-** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ** | | **360,000.00** | **15,489,687.40** |
| Хөрөнгө худалдсаны гарз | | 360,000.00 | |
| Бусад гарз | | | 15,489,687.40 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)** | | **(360,000.00)** | **(15,489,687.40)** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН** | | **49,361,426.69** | **21,407,507.98** |
| **Хяналтын хувь оролцоонд хамаарах үр дүн** | | | |
| **Хяналтын бус хувь оролцоонд хамаарах үр дүн** | | | |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

***/төгрөгөөр/***

| ҮЗҮҮЛЭЛТ | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|
| **Татаас, санхүүжилтийн орлого** | **1,282,773,000.00** | **1,357,533,300.00** |
| Урсгал | 1,282,773,000.00 | 1,357,533,300.00 |
| **Бараа, үйлчилгээний орлого** | **650,454,699.21** | **603,819,632.09** |
| Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого | 259,758,369.06 | 310,725,257.09 |
| ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | 251,903,831.88 | 287,826,875.00 |
| Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | 121,616,800.00 | 3,827,500.00 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,880,000.00 | 1,440,000.00 |
| Бусад орлого | 14,295,698.27 | |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,933,227,699.21** | **1,961,352,932.09** |
| **Ажиллагчидтай холбогдсон зардал** | **1,259,776,440.88** | **1,473,809,189.25** |
| **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,121,056,813.84** | **1,308,178,998.23** |
| Цалин | 519,569,596.31 | 603,991,977.27 |
| Цалингийн тусгай нэмэгдлүүд | 601,487,217.53 | 704,187,020.96 |
| **Нийгмийн хамгааллын шимтгэл** | **138,719,627.04** | **165,630,191.02** |
| Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл | 117,981,687.90 | 139,435,475.99 |
| Эрүүл мэндийн даатгалын хураамж | 20,737,939.14 | 26,194,715.03 |
| **Бараа ,үйлчилгээний урсгал зардал** | **659,155,560.06** | **501,839,441.11** |
| **Тогтмол зардал** | **53,200,000.00** | **80,113,046.12** |
| Гэрэл цахилгааны зардал | 12,200,000.00 | 7,998,772.65 |
| Түлш, халаалтын зардал | 36,000,000.00 | 68,859,703.47 |
| Цэвэр, бохир усны зардал | 5,000,000.00 | 3,254,570.00 |
| **Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал** | **165,135,800.00** | **59,817,560.00** |
| Хоол | 1,500,000.00 | |
| Бусад бараа үйлчилгээний зардал | 121,616,800.00 | 3,877,500.00 |
| Бичиг хэргийн материал | 10,480,000.00 | 15,512,200.00 |
| Тээвэр, шатахууны зардал | 1,700,000.00 | 4,381,000.00 |
| Шуудан холбооны зардал | 3,632,000.00 | 3,765,200.00 |
| Дотоод томилолтын зардал | 4,034,000.00 | 10,500,000.00 |
| Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 1,020,000.00 | 10,407,000.00 |
| Жижиг эд хогшил худалдан авах зардал | 2,040,000.00 | 2,217,280.00 |

| | | |
|---|---|---|
| Төлбөр, хураамж, жижиг татварууд | 373,000.00 | 3,481,780.00 |
| Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 15,340,000.00 | 5,573,600.00 |
| Урсгал засварын зардал | 3,400,000.00 | 102,000.00 |
| **Хөтөлбөр арга хэмжээний зардал** | **440,819,760.06** | **361,908,834.99** |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 113,418,300.00 | |
| Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал | 34,563,091.00 | 250,000.00 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 30,200,000.00 | |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,088,868.00 | 49,493,577.90 |
| Хөрөнгийн | 260,397,501.06 | 311,589,257.09 |
| Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт | 1,152,000.00 | 576,000.00 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)** | **1,918,932,000.94** | **1,975,648,630.36** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **14,295,698.27** | **(14,295,698.27)** |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН(IV)** | **-** | |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН(V)** | **-** | **-** |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV) - (V)** | **-** | **-** |
| **САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII)** | **-** | **-** |
| **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX) = (VII) + (VIII)** | **14,295,698.27** | **(14,295,698.27)** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **14,295,698.27** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **14,295,698.27** | **-** |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцоо | Дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан үр дүн | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| 2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 38,850,000.00 | 8,464,919.67 | 235,813,841.49 | **283,128,761.16** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга | | | | **-** |
| **Залруулсан үлдэгдэл** | | | | **-** |
| Тайлант үеийн үр дүн | | | 21,407,507.98 | **21,407,507.98** |
| 2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | **38,850,000.00** | **8,464,919.67** | **257,221,349.47** | **304,536,269.14** |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*/төгрөгөөр/*

| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **Татаас, санхүүжилтийн орлого** | **1,367,668,500.00** | **1,357,533,300.00** | **(10,135,200.00)** | **99.26** |
| Улсын төсвөөс | 1,367,668,500.00 | 1,357,533,300.00 | **(10,135,200.00)** | 99.26 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,367,668,500.00** | **1,357,533,300.00** | **(10,135,200.00)** | **99.26** |
| **Ажиллагчидтай холбогдсон зардал** | **1,229,064,500.00** | **1,210,286,550.89** | **(18,777,949.11)** | **98.47** |
| **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,088,901,800.00** | **1,074,081,651.46** | **(14,820,148.54)** | **98.64** |
| Цалин | 592,718,100.00 | 587,310,886.18 | (5,407,213.82) | 99.09 |
| Цалингийн тусгай нэмэгдлүүд | 496,183,700.00 | 486,770,765.28 | (9,412,934.72) | 98.10 |
| **Нийгмийн хамгааллын шимтгэл** | **140,162,700.00** | **136,204,899.43** | **(3,957,800.57)** | **97.18** |
| Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл | 117,736,700.00 | 114,692,131.30 | (3,044,568.70) | 97.41 |
| Эрүүл мэндийн даатгалын хураамж | 22,426,000.00 | 21,512,768.13 | (913,231.87) | 95.93 |
| **Бараа ,үйлчилгээний урсгал зардал** | **138,604,300.00** | **112,243,106.12** | **(26,361,193.88)** | **80.98** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Тогтмол зардал** | **93,724,000.00** | **80,113,046.12** | **(13,610,953.88)** | **85.48** |
| Гэрэл цахилгааны зардал | 13,161,300.00 | 7,998,772.65 | (5,162,527.35) | 60.77 |
| Түлш, халаалтын зардал | 75,973,900.00 | 68,859,703.47 | (7,114,196.53) | 90.64 |
| Цэвэр, бохир усны зардал | 4,588,800.00 | 3,254,570.00 | (1,334,230.00) | 70.92 |
| **Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал** | **44,880,300.00** | **32,130,060.00** | **(12,750,240.00)** | **71.59** |
| Бичиг хэргийн материал | 21,646,100.00 | 15,512,200.00 | (6,133,900.00) | 71.66 |
| Тээвэр, шатахууны зардал | 2,621,000.00 | 2,621,000.00 | - | 100.00 |
| Шуудан холбооны зардал | 4,590,300.00 | 3,765,200.00 | (825,100.00) | 82.03 |
| Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 1,017,000.00 | 357,000.00 | (660,000.00) | 35.10 |
| Жижиг эд хогшил худалдан авах зардал | 2,331,000.00 | 2,217,280.00 | (113,720.00) | 95.12 |
| Төлбөр, хураамж, жижиг татварууд | 3,923,100.00 | 1,981,780.00 | (1,941,320.00) | 50.52 |
| Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 8,091,400.00 | 5,573,600.00 | (2,517,800.00) | 68.88 |
| Урсгал засварын зардал | 660,400.00 | 102,000.00 | (558,400.00) | 15.45 |
| **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | **1,367,668,800.00** | **1,322,529,657.01** | **(45,139,142.99)** | **96.70** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 14,295,698.27 | 14,295,698.27 | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | - | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*/төгрөгөөр/*

| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **Татаас, санхүүжилтийн орлого** | | **291,654,375.00** | **(291,654,375.00)** | |
| ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | | 287,826,875.00 | (287,826,875.00) | |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 3,827,500.00 | (3,827,500.00) | |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | | **291,654,375.00** | **(291,654,375.00)** | |
| **Ажиллагчидтай холбогдсон зардал** | | **263,522,638.36** | **(263,522,638.36)** | |
| **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | | **234,097,346.77** | **(234,097,346.77)** | |
| Цалин | | 16,681,091.09 | (16,681,091.09) | |
| Цалингийн тусгай нэмэгдлүүд | | 217,416,255.68 | (217,416,255.68) | |
| **Нийгмийн хамгааллын шимтгэл** | | **29,425,291.59** | **(29,425,291.59)** | |
| Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл | | 24,743,344.69 | (24,743,344.69) | |
| Эрүүл мэндийн даатгалын хураамж | | 4,681,946.90 | (4,681,946.90) | |
| **Бараа ,үйлчилгээний урсгал зардал** | | **26,387,500.00** | **(26,387,500.00)** | |
| **Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал** | | **26,137,500.00** | **(26,137,500.00)** | |
| Бусад бараа үйлчилгээний зардал | | 2,327,500.00 | (2,327,500.00) | |
| Тээвэр, шатахууны зардал | | 1,760,000.00 | (1,760,000.00) | |
| Дотоод томилолтын зардал | | 10,500,000.00 | (10,500,000.00) | |
| Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | | 10,050,000.00 | **(10,050,000.00)** | |
| Төлбөр, хураамж, жижиг татварууд | | 1,500,000.00 | (1,500,000.00) | |
| **Хөтөлбөр арга хэмжээний зардал** | | **250,000.00** | **(250,000.00)** | |
| Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал | | 250,000.00 | **(250,000.00)** | |
| **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | | **289,910,138.36** | **(289,910,138.36)** | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - | **-** | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | - | - | |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1 алдаа[1] илэрснийг залруулав

***Илрүүлэлт:*** Санхүүгийн тайлан, тодруулгыг Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалын 2-р хавсралт *"Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"*- ын дагуу тайлангийн тодруулгыг бэлтгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2 дугаар зүйлийн 20.2.3.*"холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах"* гэж заасантай нийцээгүй байсныг санхүүгийн програмтай нийцүүлж залруулав.

### 3.1 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тавигдаагүй.

### 3.2 Албан шаардлага

Санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөгдөөгүй

### 3.1 Зөвлөмж

Санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

***/мянган төгрөгөөр/***

| № | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **1** | Санхүүгийн тайлан, тодруулгыг Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалын 2-р хавсралт *“Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"*-ын дагуу бэлтгээгүй байна | 1 | | | | 1 | | 1 | | | | | |
| | Дүн | 1 | | 1 | | 1 | | 1 | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

***/мянган төгрөгөөр/***

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | |
| 1 | Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын /төвлөрүүлэх шилжүүлэг/ 5 гүйлгээ, орлогын 12 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 1 | 0.0 | | | 1 | 0.0 |
| | **Дүн** | **1** | **0.0** | | | **1** | **0.0** |